

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ТӨРӨӨС ЭМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр
нөлөө”-нд хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: АГГ-2021/14-ШТА-ГА

Чойбалсан хот 2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Дэлгэрмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn
Аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
Гэрээт аудитор Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn
Гэрээт аудитор Ч.Удвалноров
Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товъёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6

БҮЛЭГ 1. ЭМИЙН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ХАНГАЛТГҮЙ, ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭМИЙН САН, ЭМ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУД, СУМДЫН ЭРГЭЛТИЙН ЭМИЙН САНГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ДУТАГДАЛТАЙ

БАЙНА..... 7

A.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт үр дүнтэй байгаа боловч удирдлагын мэдээллийн системийн ил тод байдал хангалтгүй байна..... 7

A.1.1. Эмийн бүртгэлийн асуудал орон нутагт хамаардаггүй байна..... 7

A.1.2. Эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдсан байна..... 8

A.1.3. Орон нутагт эмийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж бүртгэгдээгүй байна..... 8

A.1.4. Удирдлагын мэдээллийн системийн ил тод байдал хангалтгүй байна..... 8

A.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй эмийн санхүүжилтийг хугацаанд нь олгосон байна..... 8

A.2.1. Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байгаа ч эмийн үнийн дээд хязгаарыг бодитой гаргахгүй байна..... 8

A.2.2. Санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах өндөр өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж байгаа ч тусламж, үйлчилгээний нэр төрлийн суурь тарифыг зах зээлийн үнэтэй уялдуулах мөн шаардлагатай тусламж үйлчилгээний үйлдлийн оношийг бүрэн оруулаагүй байна..... 9

A.2.3. Ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эмийн зардлыг санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлдэггүй байна..... 10

A.3.Эмийн зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа харилцан уялдаатай хэдий ч аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн эмийн сан болон эм ханган нийлүүлэх байгууллагуудад хүний нөөцийн бодлого алдагдаж, сумдын эмийн эргэлтийн сангийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхой болгох шаардлагатай байна..... 10

A.3.1. Эмийн зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа харилцан уялдаатай, нэгдсэн зохицуулалттай байна..... 11

A.3.2. Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн эмийн сан болон эм ханган нийлүүлэх байгууллагуудын ажиллах хүчин хангалтгүй байна.....

A.3.3. Сумдын эмийн эргэлтийн сангийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхой болгох, иргэдийн дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зэрэг ажлыг эрчимжүүлэх нэн шаардлагатай байна..... 13

A.3.4. Эм зүйн мэргэжлийн боловсон хүчнийг сургалтад хамруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна..... 16

БҮЛЭГ 2. ЭМИЙН ЖОР БИЧИЛТ, ЭМ ОЛГОЛТОД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА Ч ЗӨРЧИЛ АРИЛАХГҮЙ БАЙГААГААС ГАДНА ИРГЭДЭД ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭНИЙ БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....16

Б.1. Аймгийн хэмжээнд “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг үнэлж, дүгнээгүй боловч үүнтэй холбоотой аймгийн “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн явцад хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна..... 17

B.1.1. Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө байхгүй ч түүнтэй холбоотой аймгийн “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна.....17

B.1.2. Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад тусгайлан хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй ч аймгийн “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна..... 18

B.1.3. Аймгийн “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд эцсийн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа болоогүй байна..... 18

Б.2. Эмийн жор бичилт, эм олголтод тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа ч зөрчил арилахгүй байгаагаас гадна иргэдэд эмийн зохистой хэрэглээний боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил хангалтгүй байна..... 18

Б.2.1. Эмийн жор бичилт, эм олголтод тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа ч зөрчил арилахгүй байна.....	18
Б.2.2. Эм зүйн ба эмнэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрдсэн байна.....	19
Б.2.3. Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт эмийн талаар баримтлах бодлогын асуудалд мэргэжлийн холбооны саналыг аваагүй байна.....	20
Б.2.4. Иргэдэд эмийн зохистой хэрэглээний боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил хангалтгүй байна.....	22
Холбогдох байгууллагын санал:	22
ДҮГНЭЛТ:	23
САНАЛ:	24
ЗӨВЛӨМЖ:	24
ТУШААЛ:	25

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТАБ	Төрийн аудитын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
УИХ	Улсын Их Хурал
ЭМДЕГ	Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний зөвлөл
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
ЭМС	Эрүүл мэндийн сайд
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
УАУТ	Уламжлалт анагаах ухааны төв
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭЗШУИС	Эм зүйн шинжлэх ухааны их сургууль
АУДС	Анагаах ухааны дээд сургууль
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
MNS	Mongolian national standard
ЭЭС	Эмийн эргэлтийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СЭМТ	Сумын Эрүүл мэндийн төв

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Дорнод аймгийн хувийн хэвшлийн эмийн сан болон эм ханган нийлүүлэх байгууллагуудын нийт хүн хүчний хангамжийг стандарттай харьцуулсан шинжилгээ	12

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Дорнод аймгийн хэмжээнд эм зүйч, эм найруулагчийн тоо болон байршлын нэгдсэн үзүүлэлт	11
Дүрслэл 2	Дорнод аймгийн хэмжээнд эмийн зохицуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн үйл ажиллагааны бүтэц	13

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитын зорилт

**Аудитын хамарсан
хүрээ**

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх
мэдэгдэл**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдэв, МУЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөөг үндэслэн хийлээ.

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, Үндэсний аудитын газарт хүргүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хүн амыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх тогтолцоо бүрдсэн эсэх;
- Төрөөс эмийн талаар баримтлах бодлого хэрэгжсэнээр хүн амын өвчлөлт буурч, эмийн зохистой хэрэглээ төлөвшсөн эсэх.

Аудитад төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааг зохион байгуулан, бүх түвшинд хэрэгжилтийг хангуулж байгаа төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа эмийн талаар бодлогыг хангахтай холбогдсон асуудал эрхэлсэн байгууллага бусад холбогдох байгууллагын 2018-2020 оны аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит, Тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим", MNS 6817-7:2020 "Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит" стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Я.Зориг, С.Энхбаатар, гэрээт аудитор Б.Оюунхэрлэн, Ч.Удвалноров нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын дэд төлөвлөгөөг 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр батлуулж, талбарын ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн гүйцэтгэж, 2021 оны 11 дүгээр сарын 05-ны дотор дуусган тайланг ҮАГ болон холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

БҮЛЭГ А. Эмийн удирдлагын мэдээллийн системийн ил тод байдал хангалтгүй, хувийн хэвшлийн эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагууд, сумдын эргэлтийн эмийн сангийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого дутагдалтай байна.

А.1 Эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт үр дүнтэй байгаа боловч удирдлагын мэдээллийн системийн ил тод байдал хангалтгүй байна.

А.1.1. Эмийн бүртгэлийн асуудал орон нутагт хамаардаггүй байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 22 дугаар зүйлд үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2015 оны 13 дугаар “Эм, эмийн түүхий эдийг бүртгэх журам шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн үйл ажиллагааг Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвд явуулдаг байна. Орон нутгийн хувьд эмийг бүртгэх үйл ажиллагаа хамаардаггүй байна.

Монгол улсын эмийн бүртгэлд шинэ эмийг бүртгэх асуудлыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зохион байгуулдаг. Монгол Улсын эмийн бүртгэлд эмчилгээний өндөр идэвхтэй, чанартай, аюулгүй эмийг өнөөгийн хэрэгцээ, шаардлага, өвчлөлийн байдал, бодит судалгаанд үндэслэн бүртгэх асуудлыг эрх бүхий төрийн байгууллагууд гүйцэтгэдэг байна.

А.1.2 Эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдсан байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар жил бүр Эрүүл мэндийн газраас зайлшгүй шаардлагатай 700 гаруй нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

2021 оны эхний хагас жилд шаардлагатай 58 багцын 552,6 сая төгрөг, хоёрдугаар хагаст шаардлагатай 66 багцын 896.2 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг Сангийн яамны www.tender.gov.mn цахим системээр зохион байгуулсан байна.

Эмийн сонголт, эмийн зохистой хэрэглээ Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь заалтыг үндэслэн эмийн хангамж, хүртээмжийг сайжруулах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Жагсаалт шинэчлэн

батлах тухай” 350 дугаар тушаалаар зайлшгүй шаардлагатай эмийн 8 дахь жагсаалтаар 500 гаруй эмийн жагсаалт, анхааруулга, насны хязгаар, тайлбар тэмдэглэгээний хамт баталсан байна.

Хүн ам, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагыг эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах ажлыг Монгол улсад 40 гаруй эм ханган нийлүүлэх байгууллага, аж ахуйн нэгжүүд гүйцэтгэж байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа 4 эм ханган нийлүүлэх байгууллага, 34 эмийн сангийн үйл ажиллагаанд Эм хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага MNS5530:2014, Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

А.1.3 Орон нутагт эмийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж бүртгэгдээгүй байна.

Орон нутгийн түвшинд 2018-2021 онд эмийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж бүртгэгдээгүй байна.

Тухайн жилд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах үйл ажиллагаанд Сангийн Сайдын 335 дугаар тушаалд тусгагдсан Монгол Улсын үйлдвэрийн гарал үүсэлтэй эм, эмнэлгийн хэрэгслийг тусад нь багцлан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу дотоодын давуу эрхийн зөрүүг 10 хувиар тооцож, үндэсний үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэн ажилласан байна.

А.1.4 Удирдлагын мэдээллийн системийн ил тод байдал хангалтгүй байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлэх, хөгжүүлэх нь орон нутагт хамааралгүй, ЭМЯ-нд хамааралтай асуудал байна.

УИХ-ын 2014 оны 57 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс эмийн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2014 оны 425 дугаар тушаалаар батлагдсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө” батлагдаж, төлөвлөгөөний 1.1.4 дэх хэсэгт “[Licemed /http://licemed.mohs.mn/](http://licemed.mohs.mn/) программыг сайжруулж, бүртгэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод болгох” гэж заасан боловч иргэн хүн ашиглахад ойлгомжгүй, нэвтрэх нэр шаардсан, мэдээллийн баяжилт дутмаг байдалтай байна.

А.2 Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй эмийн санхүүжилтийг хугацаанд нь олгосон байна.

А.2.1 Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байгаа ч эмийн үнийн дээд хязгаарыг бодитой гаргахгүй байна.

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын 7.4.1-т “Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэж заасан бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 25-

ны өдрийн 13 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээний жагсаалтыг шинэчлэн баталсан байна. Үүнд 139 төрлийн ерөнхий нэршлийн 574 төрлийн худалдааны нэршлийн эмийг эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөхөөр тусгасан байна.

Аймгийн хэмжээнд нийтийн үйлчилгээтэй улсын 13, хувийн хэвшлийн 25 эмийн сан ЭМДЕГ-тай гэрээ байгуулж ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээний жагсаалтад заасан зарим эмийн үнийн дээд хязгаар нь эм ханган нийлүүлэх төвийн эмийн үнэтэй дүйцэхүйц байгаа нь хувийн хэвшлийн эмийн сангуудад хүндрэл учруулж, алдагдалтай үнээр даатгуулагчдад үйлчлэхэд хүргэж байна. Мөн удаан хэрэглэгддэг эмийн хөнгөлөгдөх тоо хэмжээ нь эмчилгээндээ хүрэлцэхгүй байх тохиолдлууд байна. Цар тахлын үед вирусийн эсрэг эмүүд эрэлт ихтэй байгаа бөгөөд үүнд хөнгөлөгдөхгүй байгаа нь иргэдэд санхүүгийн дарамт учруулж байна. Учир нь вирусийн эсрэг эм нь өндөр өртөгтэй эмийн тоонд ордог байна.

Энэ нь эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл эмийн үнийн дээд хязгаарыг гаргахдаа бодит тооцоо, судалгаанд үндэслээгүй, цаг үеийн нөхцөл байдалд тулгуурлан шаардлагатай эмийг жагсаалтад нэмж оруулах зохицуулалт байхгүй зэрэгтэй холбоотой байна.

Үүнтэй холбоотойгоор хувийн хэвшлийн эмийн сангаас тус жагсаалтад багтсан зарим нэр төрлийн эмийг даатгуулагчид олгохгүй байх нөхцөл байдалд хүрч байна.

А.2.2 Санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах өндөр өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж байгаа ч тусламж, үйлчилгээний нэр төрлийн суурь тарифыг зах зээлийн үнэтэй уялдуулах мөн шаардлагатай тусламж үйлчилгээний үйлдлийн оношийг бүрэн оруулаагүй байна.

Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх зохицуулалт нь эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.6, Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний Зөвлөл /ЭМДҮЗ/-ийн 2020 оны 5 дугаар тогтоолоор тусгайлан зохицуулагдаж байсныг ЭМДҮЗ-ийн 2021 оны 1-р сарын 22-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад оруулж нэгтгэсэн байна.

Тус тогтоолд үндсэн онош нь орсон боловч үйлдлийн онош нь бүрэн ороогүйгээс ангилагдаагүй бусад гэсэн оношийн хамааралтай бүлгээр 230,0 мянган төгрөгөөр бодогдож 195,5 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байгаа нь эрүүл мэндийн байгууллагын бодит өртгийг хангаж чадахгүй байна.

Мөн нийт тусламж, үйлчилгээний нэр төрлийн суурь тариф нь үнийн өсөлттэй уялдахгүй байгаагаас тусламж үйлчилгээний тариф нь зах зээлийн үнээс доогуур бодогдож байна.

Үүнээс шалтгаалж даатгуулагчдад санхүүгийн дарамт үүсгэхээс бүрэн сэргийлж чадахгүй, эрүүл мэндийн байгууллагын бодит өртгийг нөхөж чадахгүй байна.

А.2.3 Ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эмийн зардлыг санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлдэггүй байна.

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын 7.4.3-т “Ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эмийн зардлыг санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэж заасан.

Ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эмийг эрүүл мэндийн даатгалаас ямар нэгэн хөнгөлөлт, чөлөөлөлттэй олгох зохицуулалт байхгүйн улмаас дээрх заалт орон нутгийн түвшинд хэрэгжихгүй байна.

А.3 Эмийн зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа харилцан уялдаатай хэдий ч аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн эмийн сан болон эм ханган нийлүүлэх байгууллагуудад хүний нөөцийн бодлого алдагдаж, сумдын эмийн эргэлтийн сангийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхой болгох шаардлагатай байна.

А.3.1 Эмийн зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа харилцан уялдаатай, нэгдсэн зохицуулалттай байна.

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын 9.1.1-д “Эмийн зохицуулалт, хяналтын үйл ажиллагааг төрийн зүгээс нэгдсэн зохицуулалтаар хангаж, бэхжүүлэх”, 9.1.2-т “Эмийн зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллага нь эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрөл, эм зүйн мэргэжилтний зөвшөөрөл, зохистой дадлын зөвшөөрөл, түүний хяналт шалгалт, эмийн улсын бүртгэл, бүртгэлийн дараах тандалт судалгаа, эмийн аюулгүй байдлын хяналт, үнэлгээ /фармаковижиланс/, эмнэл зүйн судалгааны үнэлгээ, эмийн чанарын хяналт, эмийн импорт, экспортын хяналт болон эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг зохицуулж, олон улсын ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах”, 9.1.3-т “Төрөөс эмийн зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллагын тогтвортой үйл ажиллагаа, санхүүгийн болон мэргэшсэн хүний нөөцийг бэхжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааны уялдааг сайжруулахад бүх талаар дэмжлэг үзүүлэх” гэж заасан байна.

Эмийн зохицуулалт хяналтын чиг үүрэг бүхий байгууллагууд болох эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газрууд нь тус тусын чиг үүргийн хүрээнд эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагуудад хяналт тавьдаг бөгөөд эрүүл мэндийн байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгох, сунгах, эрүүл мэндийн даатгалтай гэрээ байгуулах зэрэг ажлуудад тусгай комисс гарган хамтран ажилласан байна. Мөн эм хангамжийн байгууллага, эмийн сангуудад стандартын хэрэгжилтийн үнэлгээг АЗДТГ, ЭМГ, МХГ, ЭМДХ, Цагдаагийн газар зэрэг төрийн


байгууллагууд хариуцах чиг үүргийн хүрээнд хамтран зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан байна.

А.3.2 Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн эмийн сан болон эм ханган нийлүүлэх байгууллагуудын ажиллах хүчин хангалтгүй байна.

Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09 сарын 04-ний өдрийн А/406 дугаар тушаалаар “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” батлагдсан бөгөөд уг тушаалаар 2016 оны “Эм зүйч, эм найруулагчийн ёс зүйн хэм, хэмжээ, эрх, үүрэг батлах тухай” 32 дугаар тушаал хүчингүй болсон байна.

Иймд Дорнод аймгийн хэмжээнд эм зүйч, эм найруулагчийн тусгайлсан ёс зүйн дүрэм байхгүйгээс ЭМС-ын А/406 дугаар тушаал “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийг дагаж мөрдөж байна. Дорнод аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд эм зүйч, эм найруулагчаас гарсан ёс зүйн зөрчил гараагүй байна.

Дүрслэл 1. “Дорнод аймгийн хэмжээнд эм зүйч, эм найруулагчийн тоо болон байршлын нэгдсэн үзүүлэлт”



Дорнод аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн эм зүйч 28, эм найруулагч 40, нэг эмийн сангийн эрхлэгч сувилагч мэргэжилтэй байна. (Дүрслэл 1-ээр үзүүлэв.) Одоогийн байдлаар нийт 34 эм ханган нийлүүлэх төв, эмийн санд 59 эм зүйч, эм найруулагч ажиллаж байгаагаас 98,7 хувь нь мэргэжлийн боловсон хүчнээр хангагдан ажиллаж байна. Сумын нийт 13 эргэлтийн эмийн сан 100 хувь мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байна.

Нийт эм зүйч, эм найруулагчдаас клиник эм зүйч 1, эмнэл зүйн магистр 1, эмнэл зүйн эм зүйч 1, эм найруулагч эм зүйгээр сурч байгаа 1, ЭЗШУИС-н эм зүйн албаны зохион байгуулалт 6 сарын курс төгссөн 1, 2019.11.14-нд 1 багц цагийн "Эмнэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга зам" сэдэвт сургалтад хамрагдсан 1 гэсэн байдлаар тус тус мэргэжил дээшлүүлж давтан сургалтад хамрагдсан байна.

Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 Монгол Улсын стандартын 5.5-д “Эмнэлгийн эмийн санг эм зүйн албаны менежментээр эсвэл клиникийн эм зүйн чиглэлээр

мэргэшсэн эм зүйч удирдаж, эрхлэгчийн үүргийг гүйцэтгэнэ” гэж заасны дагуу БОЭТ-ийн 14 тасагт нийт хэвтэн эмчлүүлэх орны тоо 320 байна.

Аймгийн хэмжээнд хувийн 4 ортой эмнэлэгт эмнэлгийн эмийн сан байхгүй байна. Иймд дээрх стандартын А хавсралт “Хүн хүчний хангамж”-ийн дагуу ($320/50=6,4$) 6-7 клиник эм зүйч ажиллах ёстой байна. Нийт 10 эм зүйч, 2 эм найруулагч байх ёстойгоос 2021 оны байдлаар 3 эм зүйч, 2 эм найруулагч ажиллаж байна. Үүнээс харахад БОЭТ-д клиник эм зүйч 6-7 дутуу байна. Сумдын эргэлтийн эмийн сан болон УАУТ-д хүн хүчний хангамж болох эм зүйч, эм найруулагчид стандартын дагуу хангалттай гэж үзэж байна.

Нийт эм зүйч, эм найруулагчдын 45,5 хувь нь 10-аас дээш жил ажилласан эм зүйч, эм найруулагч байна. Давтан сургалтад хамрагдсан байдал хангалтгүй байна. Дорнод аймгийн хэмжээд хувийн хэвшлийн эмийн сан болон эм ханган нийлүүлэх байгууллагуудын хүн хүчний хангамжийг MNS 5260:2015 стандартын дагуу дараах байдлаар авч үзэв.

Хүснэгт 1. “Дорнод аймгийн хувийн хэвшлийн эмийн сан болон эм ханган нийлүүлэх байгууллагуудын нийт хүн хүчний хангамжийг стандарттай харьцуулсан шинжилгээ”

д/д	Эмийн сангийн зэрэглэл	Эмийн сангийн тоо	Хүн хүчний хангамжийн стандарт	Нийт хүн хүчний хангамжийн стандарт
1	Хувийн хэвшлийн эмийн сан болон эм ханган нийлүүлэх байгууллагууд (1=2+5)	34		
2	1-р зэрэглэлийн эмийн сан (2=3+4)	12		
3	24 цагаар ажилладаг	1	7	7
4	8 цагаар ажилладаг	11	5	55
5	2-р зэрэглэлийн эмийн сан (5=6+7)	22		
6	24 цагаар ажилладаг	1	4	4
7	8 цагаар ажилладаг	21	2	42
8	Нийт хүн хүчний хангамжийн тоо (8=3+4+6+7)			108

Эх сурвалж: Судлаачийн зүгээс тооцоолсон байдал.

Дорнод аймгийн хэмжээнд 34 хувийн хэвшлийн эмийн сан болон эм ханган нийлүүлэх байгууллагуудын одоогийн ажиллаж буй нийт ажиллах хүчин 59 эм зүйч, эм найруулагч ажиллаж байгаа боловч MNS 5260:2015 стандартын дагуу 108 байх ёстой гэж үзвэл 59/108 буюу нийт ажиллах хүчний дөнгөж 54,6 хувь нь хангагдаж байна. Эндээс үзэхэд аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн эмийн сан болон эм ханган нийлүүлэх байгууллагуудын ажиллах хүчний хангалт дутмаг байна.


Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эм зүйн мэргэшсэн хүний нөөцийн байршил, хуваарилалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлдэг боловч төрөөс дээрх хүний нөөцийн хангалт дутмаг байдалд дэмжлэг үзүүлдэггүй байна.

Харин 2006 онд анх Суманд эмийн эргэлтийн сан байгуулагдаж, хүний нөөцийг бэлтгэх зорилгоор Дорноговь дахь АУДСургуулийн Эм найруулагчийн ангид 10 гаруй сумдын бага эмч, сувилагч нар суралцаж дипломын эм найруулагчийн мэргэжлийг төрийн дэмжлэгтэйгээр эзэмшиж, сум орон нутагт ажиллаж байна. Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартын 7.1 дэх заалтыг хэрэгжүүлэх үүднээс 10 эмийн сангийн 12 эм зүйч АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийн эм зүйн албаны зохион байгуулалт, менежментийн чиглэлээр 6 сарын цахим сургалтад хамрагдахаар бүртгүүлсэн байна. Мөн 2018-2021 онд аймгийн хэмжээнд 12 эм найруулагч мэргэжил дээшлүүлэн бакалаврын эм зүйчийн мэргэжил эзэмшсэн байна. Ингэснээр төрөөс эмийн зохицуулалтын талаарх чиг үүрэг бүхий байгууллагын хүний нөөцийн бааз суурь нэмэгдэж, улмаар эм зүйч, эм найруулагчдын ажлын ачаалал багасан Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн 5 дахь эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчтэй харилцах хэм хэмжээнд заасан 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6 зэрэг заалтууд хэрэгжих бүрэн боломжтой байна.

А.3.3 Сумдын эмийн эргэлтийн сангийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхой болгох, иргэдийн дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зэрэг ажлыг эрчимжүүлэх нэн шаардлагатай байна.

Эмийн чиглэлээр 4 төрлийн хууль, 2 удаагийн Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн сайдын 24 тушаал, 9 стандарт, “Нянгийн тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө” зэргийг баталж, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журмыг 2019 оны 09 дүгээр сард шинэчлэн баталж эрх зүйн орчныг улам боловсронгуй болгосон нь сайн талтай байна. Гэвч зарим хууль, эрх зүйн баримт бичгүүдийн батлагдсан хугацаа хуучирсан, заалтуудыг шинэчлэх хэрэгцээ, шаардлага үүссэн байна. Тухайлбал, “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын хэрэгжих хугацаа дууссан тул шинэчлэн батлуулах, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг ажлууд удаашралтай байна. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/414 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагын түвшинд Эмийн эмчилгээг зохицуулах хороог шинэчлэн батлах, түүний удирдлага дор антибиотикийн дэд хороог байгуулан ажиллуулахаар журамласан байна¹.

Дүрслэл 2. “Дорнод аймгийн хэмжээнд эмийн зохицуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн үйл ажиллагааны бүтэц”



¹ Эмийн чиглэлээр хэрэгжиж буй хууль, эрх зүйн баримт бичигт хийсэн нөхцөл байдлын дүн шинжилгээ, Л.Бор, АУ-ны магистр, ХТХАА-ны мэргэжилтэн, 2020 он.

Сумдын эргэлтийн эмийн санд эмийг бүрдүүлэх тендерийг 2021 оноос эхлэн гүйцэтгэлээр санхүүжүүлэхтэй холбогдуулан орон нутгийн онцлогт тохирсон байдлаар өөрсдөө зохицуулах зааврыг Дорнод аймгийн ЭМГ-аас 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны талаар”, №1/202 албан тоот өгч ажилласан байна.

Эргэлтийн эмийн сангийн өнөөгийн байдал, үйл ажиллагаа, статус нь улсын хэмжээнд сум бүрд харилцан адилгүй байгаа бөгөөд Дорнод аймгийн хэмжээнд ЭЭС-тай холбоотой дараах тулгамдсан асуудлууд үүссэн байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн сайдын 2006 оны 53 дугаар тушаалаар сумын эмийн эргэлтийн санг орон нутгийн өмчид суурилсан хуулийн этгээд байхаар зохицуулж, эргэлтийн эмийн сангийн ажиллах журам батлан аймаг, сум бүрд удирдах зөвлөл хяналтын зөвлөлийг ажиллуулах талаар тусган эмийн эргэлтийн сангийн хөрөнгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2009 оны 28 тогтоолоор орон нутгийн өмч гэж бүртгэн авсан байна.
2. Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталж, уг тушаалаар аймагт сумын эргэлтийн эмийн санг мэргэжлийн болон санхүүгийн удирдлагаар хангах удирдах зөвлөл, суманд ЭЭС-ийн үйл ажиллагаанд хяналт тавих бүхий хяналтын зөвлөл ажиллахаар журамлан эрх үүргийг тусгасан заалттай хэрэгжиж эхэлсэн байна. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 386 дугаар тушаалаар “Сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний шинэчлэлийн стратеги /2013-2018/ батлагдсан бөгөөд уг стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.3.1-т “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журамд өөрчлөлт оруулах, 1.3.2-т Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийн бүртгэлийг улсын мэдэлд шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах”, 1.3.3-т “Эмийн эргэлтийн санд ажиллаж буй мэргэжилтнүүдийн цалингийн санг улсын төсөвт суулгаж шийдвэрлэнэ” гэж тусгагдсан заалт, Монгол улсын их хурлын 2014 оны 10 дугаар сарын 09-ны өдөр “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого батлах тухай” 57 дугаар тогтоол батлагдаж уг тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 425 дугаар тушаал батлагдан гарсан. Төлөвлөгөөний 3.5.2-т “Эмийн эргэлтийн санг сумын эрүүл мэндийн төвд нэгтгэн орон нутгийн хүн амыг шаардлагатай эмээр хангах, үйлчлэх” гэж заасан заалтууд тушаал шийдвэрүүд хоорондоо зөрчилдөж байгаатай холбоотойгоор ЭМЯ Эмийн эргэлтийн сангийн асуудлыг тодорхой шатанд шийдвэрлэх боломжгүй байсаар өнөөдрийг хүрсэн байна.
3. Эрүүл мэндийн яамны “Эмийн эргэлтийн санг сумын эрүүл мэндийн төвд шилжүүлэх тухай” 2015 оны 1а/2642 тоот албан бичиг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Эрүүл мэндийн газарт ирсний дагуу Эрүүл мэндийн газраас Эмийн эргэлтийн санг аж ахуйн нэгж болгоход гарах хүндрэлтэй асуудлуудыг тусган Сумын эрүүл мэндийн төвийн эмийн сангаар ажиллуулах тухай 2015 оны 1/343 тоот албан бичгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлсэн боловч шийдэлд хүрээгүй байна.
4. 2016 оны 1а/4515 болон 2/3874 тоот албан бичгээр Эмийн эргэлтийн сангийн асуудлыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлүүлэх тухай Эрүүл мэндийн сайд, төрийн нарийн бичгийн даргын албан бичгүүд мөн аймгийн ИТХ болон Эрүүл мэндийн газарт ирсний дагуу сумын эмийн эргэлтийн сангаас санал болон эмийн эргэлтийн сантай холбоотой мэдээллүүдийг тухай бүрд хүргүүлж ажилласан байсан.
5. 2017 оны 1а/2179 тоот албан бичигт Эмийн эргэлтийн сангийн асуудлыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн хувийн хэвшилд шилжүүлэх тухай чиглэл ирүүлсний дагуу орон нутгийн өмчийн газарт асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь зүйтэй талаар хамтран ажиллах хүсэлт хүргүүлсэн байна.
6. 2018 оны 7/153 тоот албан бичигт Эрүүл мэндийн яамны 2017 оны удирдах зөвлөлийн хурлаас Сумын эргэлтийн эмийн санг сумын эрүүл мэндийн төвд шилжүүлэх тухай зөвлөмж гарч 2011 оны 297 дугаар тушаалаар батлагдсан Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмыг мөрдөн ажиллаж, ЭЭС-ийн бүтэц, орон тоо, үйл ажиллагааны зардлын тооцоог судлан улсын төсөвт суулгах бэлтгэл ажлыг хангах чиглэл ирсний дагуу хүсэлтийг хүргүүлсэн боловч цалингийн санхүүжилтийн эм найруулагчийн тоо батлагдаагүй байна.
7. 2019 оноос хойш сумын эмийн эргэлтийн сан нь эрүүл мэндийн төвийн харьяанд ажиллаж байгаа хэдий ч СЭМТ-ийн бүтэц орон тооны стандартад эм найруулагчийн орон тоо батлагдаагүй учир эмийн сангаас цалинжих, зарим эм найруулагч нар сувилагч, ариутгагч

хавсран гүйцэтгэж орон тоогоор цалинжих зэрэг хүндрэлтэй асуудлууд байсаар байна. Тухайн асуудлыг ЭМЯ-нд удаа дараа уламжилсан боловч аймгуудын ЭМГ нь асуудлаа хэлэлцэж, ИТХ-аар асуудлыг шийдвэрлүүлэн, тогтоолыг хүргүүлэхийг чиглэл болгосон байна. Тус чиглэлийг үндэслэн тус аймгийн СЭМТ-д орон тоо батлах асуудлыг Сангийн яам, ЭМЯ хамтран шийдвэрлэнэ гэж чиглэл ирүүлсэн байна.

8. 13 сумын эрүүл мэндийн төвүүдээс эмийн эргэлтийн санг ямар статусаар ажиллах талаар санал авахад 90 хувь нь СЭМТ-ийн харьяанд эмнэлгийн эмийн сангаар ажиллуулах саналыг ирүүлж, гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулсан байна.

Цаашид эмийн эргэлтийн сангийн эмийн өрийн асуудлыг шийдвэрлэж, 13 сум өр төлбөрийн асуудалгүй болсон тохиолдолд сумдын Эрүүл мэндийн төвийн харьяанд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх шаардлага үүссэн байна. Мөн бүтэц, орон тооны асуудлыг шийдвэрлэж, цалин сан батлагдсан тохиолдолд эмийн санчийн нийгмийн баталгаа, урамшуулал, тогтвор суурьшлын асуудлыг шийдвэрлэх боломжтой байна.

Коронавирусын халдварын тархалтай холбоотой сүүлийн 2 жилд ямар нэгэн хамтын үйл ажиллагаа зохион байгуулаагүй байна. ЭМЯ-наас Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн УИХ-д өргөн мэдүүлсэн боловч, дэмжигдэж батлагдаагүй бөгөөд үнийн зохицуулалтын асуудлаас үүдэн хугацаа нь хойшлогдож, ковид-19 цар тахлын үед импортоор нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ огцом нэмэгдсэн байна.

Дорнод аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн нийтийн эмийн сангуудын нэгдсэн “Эм” холбоо ТББ нь гишүүдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хууль, тогтоомж, түүний өөрчлөлтөд санал өгөх, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах үндсэн чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор тус байгууллагын үйл ажиллагаа сүүлийн 2 жилд бүрэн зогссон учраас аудитын явцад мэдээлэл авах боломжгүй байсан. Дорнод аймагт “Эм” холбоо ТББ байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэг тодорхойгүй учраас хувийн хэвшлийн нийтийн эмийн сангууд хэрхэн эмийн зохицуулалтын чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулж байгаа, төрийн байгууллагуудтай хэрхэн уялдаж ажилладаг нь тодорхой бус байна.

Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл бодлогын баримт бичгийн 3.2.6 дахь “Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг ханган, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл хяналтыг сайжруулна” гэсэн заалтын хүрээнд: Нийтийн үйлчилгээтэй 47 эмийн санд бар кодын машин, тасалбар түгээх хэвлэгч машиныг байршуулан, үйл ажиллагаанд ашигласан байна. Коронавируст халдварын тархалт нэмэгдсэнтэй холбоотой Хэрлэн суманд 24 цагаар ажиллах 1 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг олгож, 10 эмийн сан 1 сарын хугацаанд 24 цагаар ээлжээр ажиллах хуваарийг ЭМГ-ын даргаар батлуулан иргэдэд үзүүлэх эм зүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, коронавируст халдварын тархалт ихэссэнтэй холбоотой эм хангамжийн байгууллагуудад хүний нөөцийн хомсдол үүссэн тул, эмнэлгийн бүсэд 24 цагаар ажиллах эмийн санд аймгийн Засаг даргын захирамжаар тусгай зөвшөөрөл олгох асуудлыг бодлогоор дэмжиж, шийдвэрлэсэн нь сайн талтай байна.

Орон нутгийн хөгжлийн сан, аймгийн Засаг даргын нөөц сангаас тодорхой хөрөнгийг зарцуулсны үр дүнд “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”, “Аймгийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”, “Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгасан эм зүйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, нөөц хангалт, хүртээмжтэй холбоотой зүйл заалтуудын хэрэгжилт хангалттай сайн хэрэгжсэн боловч, цаашид хөдөөгийн 13 сумын эмийн эргэлтийн сангийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхой болгох, иргэдийн дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зэрэг ажлыг эрчимжүүлэх нэн шаардлагатай байна.

Эмийн зохицуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын үүрэг хариуцлага, үйл ажиллагааг илүү нарийн тодорхойлж Засаг даргын мөрийн хөтөлбөр болон үндсэн чиглэлд тусгах, түүний хэрэгжилтийг үнэлж дүгнэхдээ тодорхой тогтоосон шалгуураар дүгнэх, орон нутаг дахь “Эм” холбоо ТББ-ын үйл ажиллагааг тогтмолжуулж, идэвхжүүлэх шаардлагатай байна.

Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн зохицуулалт нэн тэргүүнд шаардлагатай байгаа боловч одоог хүртэл хууль журамд тусгагдаагүй, өрсөлдөөний зах зээлийн тухай хуулиар үнэ тогтоох боломжгүй байдал үүссэн байна. Тухайлбал, дээрх асуудлыг эмийн зохицуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн үүрэг хариуцлагыг тодорхой болгож, ажлын уялдааг сайжруулснаар эмийн үнийн зохицуулалтыг хот, орон нутгийн ялгааг арилгах боломжууд бий болохоор байна.

А.3.4 Эм зүйн мэргэжлийн боловсон хүчнийг сургалтад хамруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

Эм зүйн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах талаар тусгайлсан эрх зүйн зохицуулалт байхгүй ч түүнд хамаарах эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалаар баталсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-аар зохицуулагдаж байна.

Аймгийн хэмжээнд эм зүйн салбарын мэргэжилтнийг бэлтгэх, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө байхгүй ч түүнд хамаарах эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэх, сургалтад хамруулахдаа аймгийн Эрүүл мэндийн газар нь орон нутгийн хэрэгцээнд тулгуурлан аймгийн Төрийн албан хаагчийн сургалт, хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын жилийн төлөвлөгөө болон холбогдох журмын дагуу эм зүйн салбарын мэргэжилтнийг мэргэшүүлэх сургалтад хамруулах үйл ажиллагааг явуулсан байна.

Аймгийн хэмжээнд эм зүйн салбарын мэргэжилтнүүдийг мэргэжлийн тасралтгүй сургалтад хамруулсан эсэхийг үзэхэд давхардсан тоогоор 215 эм зүйч, эм найруулагчийг 2018-2019 онд 8 удаагийн сургалтад хамруулах үйл ажиллагааг

хэрэгжүүлж, мэдлэг мэргэшлийг нь дээшлүүлсэн байна. Харин 2020 онд цар тахлын улмаас мэргэжлийн сургалт зохион байгуулагдаагүй байна.

Дээрх нөхцөл байдал, холбогдох тайлан материалаас үзэхэд аймгийн хэмжээнд эм зүйн салбарын боловсон хүчнийг холбогдох төлөвлөгөө, журмын дагуу мэргэжлийн сургалтад хамруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

БҮЛЭГ Б. Эмийн жор бичилт, эм олголтод тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа ч зөрчил арилахгүй байгаагаас гадна иргэдэд эмийн зохистой хэрэглээний боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил хангалтгүй байна.

Б.1 Аймгийн хэмжээнд “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг үнэлж, дүгнээгүй боловч үүнтэй холбоотой аймгийн “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн явцад хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна.

Б.1.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө байхгүй ч түүнтэй холбоотой аймгийн “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна.

Дорнод аймгийн хэмжээнд УИХ-ын 2014 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний тусгайлсан төлөвлөгөө боловсруулагдаж батлагдаагүй боловч тус бодлоготой холбоотой зарим зорилт, арга хэмжээнүүд нь 2014-2017 онд аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжсэн байна.

ЗГ-ын 2017 оны 24 дүгээр тогтоолоор “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” батлагдсан бөгөөд уг бодлогын эм зүйн салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зарим арга хэмжээнүүд нь “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдтэй холбоотой байна.

Аймгийн хэмжээнд “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг үндэслэн “Дорнод аймгийн Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ыг боловсруулж, аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан байна. Уг хөтөлбөрт хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тусгасан байна.

Аудитын явцад аймгийн Эрүүл мэндийн газар нь дэд хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж буй эсэхийг хамааруулж үзэхэд дэд хөтөлбөрийн дагуу 2017-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна. Энэ төлөвлөгөөний эм зүйн салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээнүүд нь “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-той уялдаа холбоотой байна.

Б.1.2 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад тусгайлан хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй ч аймгийн “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна.

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын 12.2-т “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн явцын үнэлгээг нэгээс доошгүй удаа хийж, үнэлгээний дүнг үндэслэн хэрэгжилтийг сайжруулах цогц арга хэмжээ авна.” гэж заасан боловч явцын үнэлгээг хэдий хугацаанд хийх нь тодорхойгүй байна.

Аймгийн хэмжээнд “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд тусгайлсан явцын хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй ч түүнтэй холбоотой зарим арга хэмжээний хэрэгжилт нь байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтэд тусгагдаж хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна.

Аудитын явцад тус бодлогын баримт бичигтэй уялдаа холбоо бүхий “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг үндэслэн баталсан “Дорнод аймгийн Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад хяналт, шинжилгээ үнэлгээг 2018-2020 онд хийсэн эсэхийг хамааруулж үзлээ.

Аймгийн Эрүүл мэндийн газар нь “Дорнод аймгийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөрийн” хэрэгжилтэд 2018-2020 онуудад явцын хяналт шинжилгээ үнэлгээг хийсэн байна.

Б.1.3 Аймгийн “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд эцсийн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа болоогүй байна.

Аудитын явцад “Аймгийн Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-т эцсийн хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн эсэхийг хамааруулж үзэхэд уг дэд хөтөлбөр нь 2017-2021 он, 2022-2026 он гэсэн 2 үе шаттай хэрэгжихээр батлагдаж, эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээ энэ онд дуусах бөгөөд эцсийн хяналт, шинжилгээ үнэлгээ хийх хугацаа болоогүй байна.

Б.2 Эмийн жор бичилт, эм олголтод тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа ч зөрчил арилахгүй байгаагаас гадна иргэдэд эмийн зохистой хэрэглээний боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил хангалтгүй байна.

Б.2.1 Эмийн жор бичилт, эм олголтод тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа ч зөрчил арилахгүй байна.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/414 дугаар тушаалаар батлагдсан эмийн эмчилгээг зохицуулах хорооны 3.2-т “Хороо дараах үүрэг гүйцэтгэнэ.” 3.2.12 дахь “Жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангалт, хүртээмж, жор бичилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах, хяналт тавьж ажиллах” гэсэн заалтын дагуу БОЭТ-ийн эмийн эмчилгээг зохицуулах хорооноос эмнэл зүйн удирдамж, эмч нарын жор бичилт, тасгийн эм олголтын

байдалд улирал бүр дүн шинжилгээ хийж, эмийн гаж нөлөө, эмийн хангалт, зарцуулалт, буцаан олголтын байдлыг үнэлж хэлэлцүүлэн тайланг жил бүр Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журамд тусгагдсан хугацаанд Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн байна.

Эмийн жорын маягт, жор бичилтийн стандарт /5376:2016 /-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг хууль журмын дагуу хэвлүүлэн түгээж, зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна.

Аймгийн Эрүүл мэндийн газраас 2012 оноос эхлэн БОЭТ-ийн эмийн эмчилгээг зохицуулах хороотой хамтран эмч нарт эмийн жор бичилтийн талаар сургалт мэдээллийг хийж хэвшүүлсэн байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жор 2017 оноос цахим хэлбэрт шилжсэнтэй холбоотойгоор БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн байгууллагуудын их эмч нарт шифр код олгож эхэлсэн бөгөөд 2018 оноос аймгийн төвийн эмийн сангууд цахим программыг бүрэн ашиглаж эхэлсэн байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2018-2020 онуудад давхардсан тоогоор нийт 51 эмийн сангийн жороор олгох эмийн олголтод хяналт шалгалт хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна. Жороор олгох эмийг жоргүйгээр олгож байсан 27 зөрчилд хугацаатай албан шаардлагыг өгч ажилласан боловч энэ зөрчил давтагдан гараад байна.

Жор бичихгүй байгаа нь эмч нар ажлын ачаалал их байна гэсэн шалтгаанаар, мөн жор бичих стандартаа сайн мэдэхгүй, жороор олгох заалттай эм бэлдмэлийг өвчтөний карт дээр бичээд жорын маягт дээр бичдэггүй, эмийн сангууд жороор олгох заалттай эмийг эмч нарын карт дээр бичсэн жороор шууд өгдөг, үйлчлүүлэгчийг алдахгүйн тулд эм бэлдмэл зохих хэрэглэх хүчинтэй хугацаа дуусахтай болон эргэлтийн хөрөнгө бага байдагтай холбоотой гэх мэт борлуулалтын хамаарлаас болж эмийг иргэдэд жоргүй олгох, иргэд эмийн зохистой хэрэглээ, хэрэглэх мэдлэг хомс, ам дамжсан ярианд итгэж эмийг авах сонирхолтой зэрэг шалтгаанууд нь жороор олгох заалттай эмийг жоргүй олгох, хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Б.2.2 Эм зүйн ба эмнэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрдсэн байна.

Дорнод аймгийн эрүүл мэндийн байгууллагад нийт 8 эм зүйч, 11 эм найруулагч ажиллаж байна. Үүнээс БОЭТ-д 5 эм зүйч, Уламжлалт анагаах ухааны төвд 1 эм зүйч, 13 сумын эргэлтийн эмийн санд 2 эм зүйч, 11 эм найруулагч ажиллаж байна.

Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 Монгол Улсын стандартын дагуу БОЭТ-д нийт 10 эм зүйч, 1 жор баригч ажиллах байтал 3 эм зүйч, 2 жор баригч ажиллаж байгаа нь хангалтгүй байна.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/414 тушаалаар батлагдсан “Эмийн эмчилгээг зохицуулах хороо”-ны 1.4 дэх заалтад заасны дагуу манай аймагт эмийн эмчилгээг

зохицуулах хороог Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд байгуулан ажилласан байна.

БОЭТ-ийн эмийн эмчилгээг зохицуулах хорооноос эмнэл зүйн удирдамж, эмч нарын жор бичилт, тасгийн эм олголтын байдалд улирал бүр дүн шинжилгээ хийж, эмийн гаж нөлөө, эмийн хангалт, зарцуулалт, буцаан олголтын байдлыг үнэлж жилд 5-6 удаа хурлаар хэлэлцүүлэн тайланг Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журамд тусгагдсан хугацаанд Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн байна.

Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам, хорооны бүрэлдэхүүнийг БОЭТ-ын захирлын 2019 оны А/22 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

Мөн Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/414 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор БОЭТ-ийн захирлын 2019 оны А/80 дугаар тушаалаар антибиотикийн дэд хорооны гишүүд, үйл ажиллагааны журмыг батлуулсан байна.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Эмийн гаж нөлөө болон аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн, мэдээлэх журам”-ын 2.1 дэх “Эмийн гаж нөлөөний мэдээллийг бүртгэх”, 2.1.1 дэх “Эмийн гаж нөлөөг бүртгэн, мэдээлэх үйл ажиллагааг амаржих газар, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв зэрэг эрүүл мэндийн байгууллагад эмийн эмчилгээг зохицуулах хороо зохион байгуулна.”, 2.2.3 дахь “Эмийн эмчилгээг зохицуулах хороогүй эрүүл мэндийн байгууллага эмийн гаж нөлөөний мэдээллийг илэрсэн тухай бүрд харьяа аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт мэдээлэх бөгөөд эмийн асуудал хариуцсан мэргэжилтэн мэдээллийг нэгтгэн Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэст ажлын 15 хоногт багтаан хүргүүлнэ” гэсэн заалтуудыг мөрдөн ажилласан байна.

Аймгийн хэмжээнд 2018-2020 онуудад эмийн гаж нөлөөний 22 тохиолдол илэрч аймгийн Эрүүл мэндийн газар болон БОЭТ нь дээрх журмын дагуу бүртгэж холбогдох газарт хүргүүлсэн байна.

Коронавируст халдварын үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай эмийн нөөц бүрдүүлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллах, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээг аймагт үйл ажиллагаа эрхэлж буй 4 эм ханган нийлүүлэх байгууллагын захирлуудтай байгуулсан байна.

Б.2.3 Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт эмийн талаар баримтлах бодлогын асуудалд мэргэжлийн холбооны саналыг аваагүй байна.

Аймгийн хэмжээнд эм хангамжийн төрийн бус байгууллагын төлөөлөл болох “Эм” холбоо ТББ үйл ажиллагаа явуулж байна. Эмийн мэргэжилтнүүдийн эрх ашиг, шагнал урамшуулал болон, нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт хийж хэрэгжүүлэх ажлын санал санаачилгыг танилцуулах, мэдээлэл солилцох чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж ирсэн байна.

Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт эмийн талаар баримтлах бодлогын асуудалд мэргэжлийн холбооноос санал авдаггүй байна.

Б.2.4 Иргэдэд эмийн зохистой хэрэглээний боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил хангалтгүй байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 17 дугаар зүйл дэх *Эмийн зохистой хэрэглээ*, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.6.2 дахь *“Эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн салбарт хэрэглэгдэж байгаа антибиотикт нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх, хянах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх”*, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.1.18 дахь *“Эмийн худалдаанд тавигдах хяналт, шаардлагыг өндөржүүлж, эмийн зохистой хэрэглээний талаар үнэн зөв мэдлэг олгож, эмийн бус эмчилгээний аргыг таниулан сурталчилна.”*, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.1.6.1 дахь *“Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, иргэд олон нийтэд “Эмийн зохистой хэрэглээ”-г төлөвшүүлэх аяныг үе шаттай зохион байгуулна.”* гэсэн заалтууд болон бусад холбогдох эрх зүйн актуудаар зохицуулагдаж байна.

Эрүүл мэндийн Сайдын 2019 оны А/414 дүгээр тушаалаар батлагдсан Эмийн эмчилгээг зохицуулах хорооны эрх, үүргийн 3.1.8-д *“Эмнэлэгт эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар санал, зөвлөмж гаргах”*, 3.1.11-д *“Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар улс, орон нутаг, байгууллагын түвшний хурал, зөвлөгөөн, ярилцлага, сургалтад оролцох, зохион байгуулах.”*, 3.2-т *“Хороо дараах үүрэг гүйцэтгэнэ.”*, 3.2.15-д *“Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй болон амбулаториор үйлчлүүлэгчдэд эмийн хэрэглээний талаарх мэдлэг олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах”* гэж заасан байдаг.

БОЭТ-ийн эмийн эмчилгээг зохицуулах хороо нь эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд *“Эмийн жорын маягт жор бичилт MNS5376:2016 стандарт, түүний хэрэгжилт”*, *“Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх нь”*, *“Эмийн эмчилгээнд гарч болох эрсдэлүүд, түүнээс сэргийлэх нь”* сэдэвт дотоодын сургалт, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэг олгох сургалтыг тогтмол зохион байгуулж хэвшсэн байна. Эмнэлгийн байгууллага, эмийн сангууд олон нийтийн сүлжээ, өөрийн фэйсбүүк пэйж хуудас, хүлээн авах болон хэвтэн эмчлүүлэгч нарт эмийн зохистой хэрэглээний боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг тухайн жилийнхээ дотоод хяналтын төлөвлөгөөндөө тусгаж зохистой хэмжээнд зохион байгуулж ажиллаж байсан.

“Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” эрхзүйн баримт бичиг 2017 онд батлагдан гарч *“Антибиотик эмийн зохистой хэрэглээ, эмд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх”* дэлхийн өдрийг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын дунд жил бүрийн 11 дүгээр сарын эхний долоо хоногт аян хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн, аянаар иргэдийн дунд хийгдсэн 2018-2019 онуудын судалгаагаар эмийн мэдлэг 5-10 хувиар нэмэгдсэн боловч хэрэглээ буурахгүй 2-5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй гарсан гэж дүгнэсэн байна.

“Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх” талаар 2020-2021 онуудад эмч, эмнэлгийн ажилтан, иргэдэд чиглэсэн сургалт, мэдээллийн үйл ажиллагаанууд тогтмол хийгдээгүй байна.

Энэ нь 2020 оноос Монгол Улсын хэмжээнд коронавируст халдварын тархалт эрчимжиж, импортоор нийлүүлэгдэх эмийн нийлүүлэлт удааширч, эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал үүсэх эрсдэл бий болсон тул эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагуудад эмийн хангалт, нөөц бүрдүүлэлтийн асуудалд илүү анхаарч, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар сургалт сурталчилгаа, уулзалт хэлэлцүүлэг, нөлөөллийн үйл ажиллагаа хийгдээгүйн улмаас иргэдийн дунд эмийн зохистой хэрэглээний мэдлэгийн түвшин буурч, хууль бус эмийн зар сурталчилгаанд автаж дур мэдэн хэрэглэх хандлага нэмэгдсэн, эмийн зохистой хэрэглээ алдагдсан гэж үнэлж, дүгнэсэн байна.

Эрүүл мэндийн Сайдын 2019 оны А/414 дүгээр тушаалаар батлагдсан Эмийн эмчилгээг зохицуулах хорооны эрх, үүргийн 3.1.8, 3.1.11, 3.2, 3.2.15-д зааснаар БОЭТ-ийн эмийн эмчилгээг зохицуулах хороо нь эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Эмийн жорын маягт жор бичилт MNS 5376:2016 стандарт, түүний хэрэгжилт”, “Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх нь”, “Эмийн эмчилгээнд гарч болох эрсдэлүүд, түүнээс сэргийлэх нь” сэдэвт дотоодын сургалт, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэг олгох сургалтыг тогтмол хийж хэвшсэн байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

463



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
21000 Чойрхалан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, Факс: 7058-4384

2021.11.02 № 1/А/ЭС

тантай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас ирүүлсэн “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Зөвлөмжийн дагуу эмийн асуудлаар төр хувийн хэвшлийн хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулах, иргэд олон нийтэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн жор бичилт, эм олголтод тавих шат шатны хяналтыг сайжруулах, эм зүйчийн орон тоог нэмэгдүүлэх, эмийн зохицуулалтын талаар төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэст үүрэг чиглэл өгч ажиллаж байна.



ЗАСАГ ДАРГАЙН
ОРЛОГЧ Ш.ЕЛ

0105 1220

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Эмийн бүртгэлийн асуудал орон нутагт хамаардаггүй байна.
2. Эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдсан байна.
3. Орон нутагт эмийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж бүртгэгдээгүй байна.
4. Удирдлагын мэдээллийн системийн ил тод байдал хангалтгүй байна.
5. Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байгаа ч эмийн үнийн дээд хязгаарыг бодитой гаргахгүй байна.
6. Санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах өндөр өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж байгаа ч тусламж, үйлчилгээний нэр төрлийн суурь тарифыг зах зээлийн үнэтэй уялдуулах мөн шаардлагатай тусламж үйлчилгээний үйлдлийн оношийг бүрэн оруулаагүй байна.
7. Ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эмийн зардлыг санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлдэггүй байна.
8. Эмийн зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа харилцан уялдаатай, нэгдсэн зохицуулалттай байна.
9. Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн эмийн сан болон эм ханган нийлүүлэх байгууллагуудын ажиллах хүчин хангалтгүй байна.
10. Сумдын эмийн эргэлтийн сангийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхой болгох, иргэдийн дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зэрэг ажлыг эрчимжүүлэх нэн шаардлагатай байна.
11. Эм зүйн мэргэжлийн боловсон хүчнийг сургалтад хамруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.
12. Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө байхгүй ч түүнтэй холбоотой аймгийн “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна.
13. Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад тусгайлан хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй ч аймгийн “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна.
14. Аймгийн “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд эцсийн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа болоогүй байна.
15. Эмийн жор бичилт, эм олголтод тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа ч зөрчил арилахгүй байна.
16. Эм зүйн ба эмнэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрдсэн байна.
17. Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт эмийн талаар баримтлах бодлогын асуудалд мэргэжлийн холбооны саналыг аваагүй байна.

18. Иргэдэд эмийн зохистой хэрэглээний боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил хангалтгүй байна.

Аудитаар нийт 7 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 4 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Удирдлагын мэдээллийн системийн /licemed.mohs.mn/ ил тод байдлыг хангуулах, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэх талаар ЭМЯ-нд уламжлах
2. Эмийн үнийн дээд хязгаарыг бодитой гаргах талаар холбогдох газарт уламжилж шийдвэрлүүлэх.
3. Тусламж, үйлчилгээний нэр төрлийн суурь тарифыг зах зээлийн үнэтэй уялдуулах, мөн шаардлагатай тусламж үйлчилгээний үйлдлийн оношийг жагсаалтад бүрэн оруулж, тогтоолд өөрчлөлт оруулах /ЭМДҮЗ-ийн 2021 оны 1-р сарын 22-ны өдрийн 03 дугаар тогтоолоор/ талаар холбогдох газарт уламжилж шийдвэрлүүлэх.
4. Эмч нарын жор бичих асуудлыг бүрэн цахимжуулах, эмч, эмийн санч болон иргэдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор зарим хууль, дүрэм журамд өөрчлөлт оруулж, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, иргэдийг багаас нь эрүүл мэндийн боловсрол олгох эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлийг боловсролын системд нь нэвтрүүлэх.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга болон Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн удирдлагуудад:

1. Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартын дагуу БОЭТ-д дутагдалтай 7 клиник эм зүйчийн орон тоог нэмэгдүүлэх. Стандартад зааснаар нийтийн эмийн санд мэргэжлийн боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэх.
2. Иргэд, олон нийтэд эмийн зохистой хэрэглээг таниулж, мэдүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх.
3. Эмийн зохицуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын үүрэг хариуцлага, үйл ажиллагааг илүү нарийн тодорхойлж Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, түүний хэрэгжилтийг үнэлж дүгнэхдээ тодорхой тогтоосон шалгуураар дүгнэж байх.

4. Орон нутаг дахь “Эм” холбоо ТББ-ын үйл ажиллагааг тогтмолжуулж, идэвхжүүлэх.
5. Эмийн жор бичилт, эм олголтод тавих шат шатны хяналтыг сайжруулах.
6. Судалгаа, сургалтын хөтөлбөрт мэргэжлийн нийгэмлэг, холбоодын саналыг харгалзах, хамтын оролцоог хангаж ажиллах.
7. Иргэдийн дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 19

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга М.Энхтөр, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010019

Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын 2-р байр, 1, 2 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn